

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ ҮНДСЭН ЧИГЛЭЛД
ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАРЫН ЗОРИЛТ,
АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ
ТАНИЛЦУУЛГА (2017 оны жилийн эцсийн байдлаар)**

Нэг. Хяналт-шинжилгээ, үнэлгээний зорилго

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэл батлах тухай УИХ-ын 2016 оны 70 дугаар тогтоолд тусгаснаар Эдийн засгийн өсөлтийг дэмжих салбаруудын бодлогын хүрээнд Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний гарц, ашиг шимийг нэмэгдүүлэх, Хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх зорилт бүхий 18 арга хэмжээг хэрэгжүүлж байна.

Хяналт шинжилгээ, үнэлгээний зорилго нь үндсэн чиглэлийн зорилт, үйл ажиллагааны гүйцэтгэлийг хүлээгдэж буй үр дүнд хүрч байгаа эсэхийг тогтоох, арга хэмжээ тус бүрийн шалгуур үзүүлэлтийн хүрсэн түвшинг тодорхойлох, шаардлагатай дүгнэлт, санал, зөвлөмж боловсруулах, хэрэгжилтийг зохион байгуулж байгаа болон шийдвэр гаргах түвшний албан тушаалтнуудад мэдээлэл, арга зүйн дэмжлэг үзүүлэхэд чиглэгдэнэ.

Хоёр. Хяналт-шинжилгээ, үнэлгээний арга зүй

Хяналтад авсан арга хэмжээнүүдийн 2017 оны хэрэгжилтийн явцад хяналт-шинжилгээ, үр дүнгийн үнэлгээг хийхдээ Засгийн газрын 2017 оны 89 дүгээр тогтоолоор баталсан “Бодлогын баримт бичгийн хэрэгжилт, захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам”-ыг удирдлага болгов. Арга хэмжээнүүдийн хэрэгжилтийн түвшинг үнэлэн тогтооход дээрх журмын “Бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх” тухай долоо дугаар бүлэгт заасныг баримтлалаа. Уг тайлангийн хавсралтыг Засгийн газрын 89 дүгээр тогтоолоор баталсан журмын 4 дүгээр хавсралтын дагуу боловсруулав.

Тус яамны Төрийн захиргааны удирдлагын газрын нэгтгэн ирүүлсэн “Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн биелэлтийн тайланг нягтлан үзэх, зарим арга хэмжээний хэрэгжилтийг хариуцсан албан тушаалтнуудтай уулзаж тодруулах замаар цуглуулсан мэдээ, мэдээлэлд үндэслэн хяналт-шинжилгээ, үнэлгээг гүйцэтгэв. Төлөвлөсөн арга хэмжээ бүрээс хэрэгжүүлэх хугацааны төгсгөлд гарах дүнг урьдчилсан байдлаар тогтоож, үнэлгээ хийх үед гарсан бодит үр дүнгийн түвшинтэй харьцуулж хувиар илэрхийлэн үнэлгээг тодорхойлов.

Гурав. Хяналт-шинжилгээ, үнэлгээний үр дүн

Хүснэгт 1. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (арга хэмжээгээр)

Зорилт	Зорилт	Арга хэмжээ	Явцын үнэлгээ			Арга хэмжээний биелэлт, жилийн эцсийн байдлаар, хувиар					Дундаж үнэлгээ, %
			Улирал			1001	702	403	04	(-)5	
			I	II	III						
- Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний гарц, ашиг шимийг нэмэгдүүлэх; -Хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын	2	18	25.0	41.1	57.8	8	4	6	0	0	73.3

¹ “үр дүнтэй” – зорилт, арга хэмжээ нь оновчтой тодорхойлогдсон, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрсэн, удирдлага, зохион байгуулалт сайн, үр дүн гарсан бол 100 хувь /90-100 хүртэл хувь/;

² “тодорхой үр дүнд хүрсэн” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ бүрэн хүрээгүй, тодорхой үр дүн гарч эхэлж байгаа, хэрэгжилт, үр дүнг нэмэгдүүлэх шаардлагатай бол 70 хувь /60-89 хүртэл хувь/;

³ “эрчимжүүлэх шаардлагатай” - зорилт, арга хэмжээ нь шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, удирдлага, зохион байгуулалт, хариуцлагыг сайжруулах, үйл ажиллагааг эрчимжүүлэх шаардлагатай бол 40 хувь /31-59 хүртэл хувь/;

⁴ “үр дүнгүй” – зорилго, зорилт, арга хэмжээг илүү сайн тодорхойлох шаардлагатай, шалгуур үзүүлэлт, зорилтот түвшиндээ хүрээгүй, төсөв, хөрөнгийг үр дүнтэй зарцуулж чадаагүй, удирдлага, зохион байгуулалт хангалтгүй бол 0 хувь /0-30 хүртэл хувь/;

⁵ “үнэлэх боломжгүй” – зорилго нь тодорхойгүй, шалгуур үзүүлэлт нь шаардлага хангаагүй, эсхүл шалгуур үзүүлэлттэй боловч гүйцэтгэлийг үнэлэхэд хангалттай мэдээлэл байхгүй, төсөв хөрөнгө тодорхойгүй, гадаад хүчин зүйлээс шалтгаалсан зэргийг баримтлан нотолсон бол.

хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх										
--	--	--	--	--	--	--	--	--	--	--

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний гүйцэтгэлд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний дүн 2017 оны жилийн байдлаар 73.3 хувьтай үнэлэгдэв. Үүнд, есөн арга хэмжээ “үр дүнтэй”, гурван нь “тодорхой үр дүнд хүрсэн”, зургаан нь “эрчимжүүлэх шаардлагатай” гэж үнэлсэн байна. “Үр дүнгүй” эсвэл “үнэлэх боломжгүй” хэмээн үнэлэгдсэн арга хэмжээ байхгүй.

Хүснэгт 2. Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх үндсэн чиглэлийн хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний товчоо (салбараар)

	2017	ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН САЛБАР					
		БТГ	МААБХЗГ	ГТБХЗГ	ХөҮБХЗГ	ЖДҮХБХЗГ	ХҮҮБХЗГ
Нийт арга хэмжээ	18	5	5	4	2	1	1
“Үр дүнтэй” (100%)	8	1	2	2	1	1	1
тодорхой үр дүнд хүрсэн (70%)	4	2	1	1	-	-	-
эрчимжүүлэх шаардлагатай (40%)	6	2	2	1	1	-	-
үр дүнгүй (0%)	-	-	-	-	-	-	-
“үнэлэх боломжгүй”	-	-	-	-	-	-	-
Үнэлгээ	73.3	64.0	70.0	77.5	70.0	100	100

Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх арга хэмжээний хэрэгжилтэд хийсэн хяналт-шинжилгээ, үнэлгээг салбар бүрээр авч үзвэл Бодлого төлөвлөлтийн газар 6 арга хэмжээг 64.0, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 5 арга хэмжээг 70.0, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 3 арга хэмжээг 77.5, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 1 арга хэмжээг 70.0, Жижиг дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 1 арга хэмжээг 100.0, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар 1 арга хэмжээг 100.0 хувийн гүйцэтгэлтэйгээр тус тус хэрэгжүүлсэн байна.

Хүснэгт 3. Үндсэн чиглэлийн санхүүжилт

	Улсын төсөв		Гадаад эх үүсвэр		Хувийн хөрөнгө оруулалт		Бусад эх үүсвэр		Дүн		
	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Төлөвлөсөн	Гүйцэтгэл	Төлөвлөсөн нийт дүн	Зарцуул. хөрөнгийн дүн	Санхүүжилтын зөрүү
Санхүүжилт, тэрбум төгрөг	84.6	118.9	14.0	24.4	15.0	-	1.3	-	114.9	140.3	25.4

2017 оны үндсэн чиглэлд улсын төсвийн хөрөнгөөс 84.56 тэрбум, гадаадын эх үүсвэрээс 14.0 тэрбум, хувийн хөрөнгө оруулалтаар 15.0 тэрбум, бусад эх үүсвэрээс 1.3 тэрбум, нийт 114.86 тэрбум төгрөгийн санхүүжилт тус тус авахаар төлөвлөснөөс жилийн эцсийн байдлаар улсын төсвөөс 140.268 тэрбум, гадаадын эх үүсвэрээс 24.4 тэрбум төгрөг тус тус зарцуулаад байна. Энэ нь төлөвлөсөн нийт дүнгээс 24.7 хувь буюу 25.4 тэрбум төгрөгөөр илүү байна. Хугацааны туршид хувийн хөрөнгө оруулалт ба бусад эх үүсвэрээс санхүүжилт хийгдээгүй байна.

Дөрөв. Дүгнэлт

Монгол Улсын эдийн засаг, нийгмийг 2017 онд хөгжүүлэх Үндсэн чиглэлийн төлөвлөгөөнд тусгагдсан хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарт хамаарах арга хэмжээний гүйцэтгэл 2017 оны жилийн эцсийн байдлаар 73.3 хувьтай үнэлэгдэв.

Үндсэн чиглэлд тусгагдсан 18 зорилт, арга хэмжээний хэрэгжилт I улиралд 25.0 хувь буюу зохих түвшиндээ хүрсэн хэдий ч II – IV улиралд жигд 15.5-17.2 хувийн өсөлттэй байсан нь жилийн эцсийн үнэлгээ 73.3 хувиар үнэлэхэд нөлөөлсөн.

Төлөвлөгдсөн 18 арга хэмжээнээс 8 нь 100 хувь, 4 нь 70 хувь, 6 нь 40 хувь хэрэгжилттэй байна.

Бодлого төлөвлөлтийн газар - 5 ажлыг 64.0, Мал аж ахуйн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар - 5 ажлыг 70.0, Газар тариалангийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар - 4 ажлыг 77.5, Хөнгөн үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар - 2 ажлыг 70.0, Жижиг, дунд үйлдвэр, хоршооны бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар - 1 ажлыг 100.0, Хүнсний үйлдвэрийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар - 1 ажлыг 100.0 хувийн үнэлгээтэйгээр гүйцэтгэсэн байна.

“Эрчимжүүлэх шаардлагатай” буюу 40 хувийн гүйцэтгэлтэй арга хэмжээнүүдийн шалтгаан нөхцлийг судалж үзэхэд нэг жилийн хугацаанд цаг хугацааны хувьд хэрэгжүүлэх боломжгүй, санхүүжилт шийдэгдээгүй, гадаад хүчин зүйлсээс нөлөөлсөн, удирдлага, зохион байгуулалт, газар хоорондын ажлын уялдаа холбооноос шалтгаалж байв.

Тав. Зөвлөмж

2019 оны Үндсэн чиглэлийг төлөвлөхдөө:

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 249 дүгээр тогтоол, “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журмын

48.1-д “төлөвлөсөн арга хэмжээ нь тухайн жилд хэрэгжүүлэх шаардлагатай байх”

48.2-т “... арга хэмжээ бүрт шаардагдах хөрөнгийн хэмжээ, санхүүжилтийн эх үүсвэр нь үндэслэлтэй, бодитой, улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр, төсвийн хүрээний мэдэгдэлд нийцсэн байх” гэсэн заалттай уялдуулж, цаг хугацаа, хүний нөөц, хөрөнгийг зөв тооцож, бодитой төлөвлөх;

2018 оны Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэхдээ:

Оны эхнээс холбогдох зорилт, арга хэмжээний хэрэгжилтийг эрчимжүүлж, тайлагналтын ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-159 дүгээр тушаалаар баталсан “Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн салбарын бодлогын баримт бичгийн хэрэгжилт, байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх аргачлал” –ын дагуу боловсруулах, тайлагналтыг сайжруулах.

**МОНГОЛ УЛСЫН ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙГ 2017 ОНД ХӨГЖҮҮЛЭХ
ҮНДСЭН ЧИГЛЭЛД ТУСГАГДСАН ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙ, ХӨНГӨН ҮЙЛДВЭРИЙН
САЛБАРЫН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ ХЭРЭГЖИЛТЭД ХИЙСЭН
ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭ, ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН**
(2017 оны жилийн эцсийн байдлаар)

Д/д	Дунд хугацааны бодлогын баримт бичиг	Арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	2017 онд хүрэх зорилтот түвшин, үр дүн	Зарцуулсан хөрөнгө, эх үүсвэр		Хүрсэн түвшин, хэрэгжилт	Хэрэгжилтийн хувь
					Төлөв /тэрбум төгрөг/	Гүйц.сэн /тэрбум төгрөг/		
ХОЁР. ЭДИЙН ЗАСГИЙН ӨСӨЛТИЙГ ДЭМЖИХ САЛБАРУУДЫН БОДЛОГО								
Зорилт 3. Мал аж ахуй, газар тариалангийн салбарын үйлдвэрлэлийг дэмжиж, бүтээгдэхүүний гарц, ашиг шимийг нэмэгдүүлнэ								
3.1	МУТХУБ-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.33 дахь заалт	Малын ашиг шимийг нэмэгдүүлэх зорилгоор малын удмын санг хамгаалж, үржил селекцийн аргаар шинэ үүлдэр, омгийг бий болгох	Импортоор авах болон дотоодод үйлдвэрлэх үхрийн гүн хөлдөөсөн үр, мян.тун	100	0.22 Улсын төсөв	0,004	“Малын зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг өргөжүүлэх аян”-ыг 2017 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс зарлан Монгол Улсын үржлийн ажлын стратегид нийцүүлэн зохиомол хээлтүүлгийн үйлчилгээг зохион байгуулж байна. Аяны хүрээнд Мал эмнэлэг, үржлийн газраас 9.1 сая төгрөгөөр санхүүжүүлэн, үржлийн үнэт чанар нь олон улсын түвшинд үнэлэгдсэн сүүний, мах-сүүний хосолмол, махны чиглэлийн өндөр ашиг шимт бухны гүн хөлдөөсөн үр, багаж, хэрэгсэл, шингэн азотоор ханган дэмжлэг үзүүлэн ажилласнаар тайлант онд 9 аймгийн 22 сум, нийслэлийн 21 дүүрэгт нийт 2100 толгой үнээг зохиомлоор хээлтүүлсэн бөгөөд хээл авалт 74,2 хувьтай байна. - Малын удмын сангийн үндэсний төвийн үндсэн үйл ажиллагаа болох шилмэл хээлтүүлэгч малаас үр үйлдвэрлэх ажлыг явуулын лабораторийн нөхцөлд гүйцэтгэн “Газар-Агро” ХХК-ийн ОХУ-аас импортлон цэврээр үржүүлж байгаа махны чиглэлийн Герфорд үүлдрийн 10 бухнаас 14.0 мянга, Дорнод аймгийн салбар нэгжид үржүүлж буй Барга үүлдрийн хуцнаас 4.0 мянган тун үрийг тус тус үйлдвэрлэн хөлдөөж Монгол улсын малын үндэсний генийн санг арвижууллаа. Ингэснээр тоо толгой нь буурч, үүлдэрлэг байдал нь алдагдан, ашиг шим нь буурч байгаа Сэлэнгэ үүлдрийн үхэр, Барга үүлдрийн хонины үржлийн чанарыг сайжруулахад чиглэгдсэн зохиомол хээлтүүлгийн ажлыг өргөжүүлэхэд шаардлагатай үрээр хангах, удмын санг нь хамгаалах боломжийг бүрдүүлээ.	40

3.2	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.32 дахь заалт	Малын гоц халдварт, халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, мал сүргийг эрүүлжүүлэх	Хамрагдах малын тоо, сая толгой	44-өөс доошгүй /68,8 сая толгой/	21.9 Улсын төсөв	17.4	<p>Улсын хэмжээнд 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар давхардсан тоогоор 540 суманд 1140 удаагийн гаралт бүртгэгдэж нийт 20 төрлийн халдварт өвчнөөр 9984 мал өвчилсний 26.4 хувь буюу 2638 мал хорогдсон байна. Халдварт өвчний гаралт, өвчлөлийг өмнөх оны тоон үзүүлэлттэй харьцуулан нь авч үзвэл сумын тоо 57, гаралт 157, хорогдол 776 тохиолдлоор тус тус буурсан байна.</p> <p>Хонины цэцэг өвчнөөс сэргийлэх вакцинжуулалтын арга хэмжээ хэрэгжүүлснээс хойш сүүлчийн тохиолдол 2017 оны 07 сард, бог малын мялзан өвчний сүүлчийн тохиолдол 2017 оны 10 дугаар сард бүртгэгдэж 2017 оны 11 сард вакцинжуулснаар өнөөдрийн байдлаар тус өвчнүүдээр тайван байна. Шүлхий өвчний тухайд 2017 оны 01 сараас эхэлсэн дэгдэлт нийт 9 аймаг, нийслэлийн 44 сум дүүргийг хамарснаас өнөөдрийн байдлаар 4 аймгийн 5 суманд хорио цээрийн дэглэм хэрэгжиж байна. Улсын хэмжээнд урьдчилсан гүйцэтгэлээр гоц халдварт өвчнөөс сэргийлэх дархлаажуулалтад нийт 47.1 /шүлхий, цэцэг, бог малын мялзан/ сая толгой мал хамруулж. үйлчилгээний хөлсөнд 7.2 тэрбум төгрөг олгохоос 5.5 тэрбум төгрөгийг олгосон байна.</p> <table border="1" data-bbox="1150 808 1934 995"> <thead> <tr> <th>Үзүүлэлт</th> <th>Хамрагдах малын тоо</th> <th>Хамрагдсан малын тоо,</th> <th>Улсын төсөв /21.9 тэрбум/</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх</td> <td>38.6 сая толгой</td> <td>47.1 сая толгой</td> <td>5.5 үйлчилгээний хөлс, 3.8 вакцин, нийт 9.3</td> </tr> <tr> <td rowspan="2">Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх</td> <td rowspan="2">43.8 сая толгой</td> <td>Бусад ХӨ 30.4 сая толгой</td> <td rowspan="2">5.6 вакцины үнэ, 2.5 үйлчилгээний хөлс, нийт 8.1</td> </tr> <tr> <td>Бруцеллёз 16.1 сая толгой</td> </tr> </tbody> </table>	Үзүүлэлт	Хамрагдах малын тоо	Хамрагдсан малын тоо,	Улсын төсөв /21.9 тэрбум/	Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	38.6 сая толгой	47.1 сая толгой	5.5 үйлчилгээний хөлс, 3.8 вакцин, нийт 9.3	Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	43.8 сая толгой	Бусад ХӨ 30.4 сая толгой	5.6 вакцины үнэ, 2.5 үйлчилгээний хөлс, нийт 8.1	Бруцеллёз 16.1 сая толгой	100
Үзүүлэлт	Хамрагдах малын тоо	Хамрагдсан малын тоо,	Улсын төсөв /21.9 тэрбум/																		
Гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	38.6 сая толгой	47.1 сая толгой	5.5 үйлчилгээний хөлс, 3.8 вакцин, нийт 9.3																		
Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх	43.8 сая толгой	Бусад ХӨ 30.4 сая толгой	5.6 вакцины үнэ, 2.5 үйлчилгээний хөлс, нийт 8.1																		
		Бруцеллёз 16.1 сая толгой																			
3.3	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.36 дахь заалт	Бэлчээрийн ашиглалт, хамгаалалтыг сайжруулах зорилгоор отрын бүс нутаг, нөөц бэлчээрийг нэмэгдүүлж, бэлчээрт хөнөөл учруулдаг мэрэгч амьтан, шавьжтай тэмцэх	нөөцөд авах нийт бэлчээрийн талбайн хэмжээ, мян.га.	750	1.8 Улсын төсөв	1.581	<p>-Улсын тусгай хэрэгцээний аймаг дундын отрын бэлчээр шинээр бий болгох судалгааны ажлын үр дүнд Хөвсгөл аймгийн Арбулаг сумын 45 мян.га, Бүрэнтогтох сумын 17.1 мян.га, Тосонцэнгэл сумын 1.0 мян.га, Цагаан-Уул сумын 17.2 мян.га, Төмөрбулаг сумын 7.6 мян.га, Цэцэрлэг сумын 87.0 мян.га нутгийг отрын бэлчээрээр ашиглах боломжтой болохыг тогтоосон. (157.8 мян.га.) Үүнээс: 2017 онд Хөвсгөл аймгийн Цэцэрлэг сумын нутаг дахь 87.0 мян га бэлчээрийг улсын тусгай хэрэгцээнд авахаар ХХААХҮ-н сайдын 2016 оны А-56 дугаар тушаалаар байгуулагдсан “Улсын тусгай хэрэгцээний отрын бэлчээрийн судалгаа хийх” үүрэг бүхий ажлын хэсэг тус суманд ажиллахаар төлөвлөсөн боловч сумын зөвшөөрөл гарахгүй байгаагаас ажил хийгдээгүй.</p>	40/0													

			Үлийн цагаан оготготой тэмцэх талбайн хэмжээ, мян.га	650 /480 мян.га/		0.117	2017 онд бэлчээрийн ургамал хамгааллын арга хэмжээнд нийт 1,7 тэрбум төгрөгөөр тодотгох судалгааг хийх, үлийн цагаан оготготой болон хөнөөлт царцаатай тэмцэх ажлыг дараах байдлаар зохион байгуулав. Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А-131 дугаар тушаалаар Ургамал хамгааллын эрдэм шинжилгээний хүрээлэнтэй тодотгох судалгаа хийх 170503/04-069 дугаар гэрээг байгуулан гүйцэтгүүлж дуусав. Үлийн цагаан оготнын тодотгох судалгааг 12 аймгийн 78 суманд хийснээс 9 аймгийн 59 суманд 380.0 мянган га бэлчээрт тэмцэх шаардлагатай дүгнэлтийг хүлээн авав. Тодотгох судалгааны дүнг үндэслэн микробиологийн болон энгийн механик аргаар үлийн цагаан оготготой тэмцэх ажлыг хийж гүйцэтгэлээ. Үүнд: Микробиологийн аргаар үлийн цагаан оготготой тэмцэх ажлыг “Шим” ХХК-тай АГГ 170407/04-052 дугаар гэрээ байгуулан 400.0 сая төгрөгөөр 5 сард Баянхонгор, Өвөрхангай аймгийн 50.0 мянган га бэлчээрт, 10 сард Өвөрхангай аймгийн Тарагт, Уянга, Нарийнтээл, Хайрхандулаан сумын 50.0 мянган га бэлчээрт нийт 100 га бэлчээрт гүйцэтгэн хүлээн авав. Энгийн механик аргаар үлийн цагаан оготготой тэмцэх ажлыг улсын төсвийн 768.0 сая төгрөгөөр 12 аймаг, аймаг дундын отрын бэлчээрт нийт 480.0 мян га бэлчээрт зохион байгууллаа.	70
			Царцаатай тэмцэх талбайн хэмжээ, мян.га	100 /89,8 мян.га/		0.036	Царцааны хөнөөлийн тодотгох судалгааг Баян-Өлгий аймгийн 5 сумын 30.0, Ховд аймгийн 6 сумын 30.0, Говь-Алтай аймгийн 3 сумын 29.8 мянган га бэлчээрт тэмцэх шаардлагатай дүгнэлт гарав. Ховд, Баян-Өлгий, Говь-Алтай аймагт 89.8 мян.га-д царцаатай тэмцэх бэлтгэл ажлын хүрээнд 119.0 мянган төгрөгөөр царцаатай тэмцэх 13.5 мянган литр Карате бодисыг худалдан авч Баян-Өлгий аймагт 6.0, Ховд аймагт 6.0, Говь-Алтай аймагт 1.5 мянган литрийг тус тус хуваарилан хүргүүлсэн. Дээрх 3 аймагт 360.0 сая төгрөгийн санхүүжилтээр 89.8 мян. га-д царцаатай тэмцэх ажлыг зохион байгуулсан.	100
3.4	МУТХУБ-ын 2.1.1, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.45 дахь заалт	Газар тариалангийн салбарт лизингийн үйлчилгээг хөгжүүлж, техник, тоног төхөөрөмжийн	Техник, тоног төхөөрөмжийн шинэчлэлийн хувь	70	14.0 Гадаад эх үүсвэр	28.3	“Газар тариалангийн техникийн шинэчлэл” төслийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд ОХУ-д үйлдвэрлэсэн хөдөө аж ахуйн зориулалттай техник худалдан авахад зориулж ОХУ-ын Хөгжлийн банкаас 10.0 сая ам.доллар (ойролцоогоор гадаадын эх үүсвэр 24.4 тэрбум, улсын төсвийн хөрөнгөөс 1.7 нийт 26.1 тэрбум төгрөг)-ын хөнгөлөлттэй зээлийг Монгол Улсын Хөгжлийн банкаар дамжуулан авав. Хөдөө аж ахуйн салбарт нэн хэрэгцээтэй 19 нэр төрлийн 543 ширхэг техник тоног төхөөрөмж	100

		шинэчлэл хийх				<p>нийлүүлснээр 48.0 мянган га талбайн уринш боловсруулах, 15.6 мянган га талбайд үр тариа тариалах, 27.3 мянган га талбайн үр тариаг технологийн хугацаанд хураан авах техник үйлдвэрлэлд шинээр нэвтрэв. Төслийн үр дүнд үр тариа үйлдвэрлэлийн техникийн шинэчлэл өнгөрсөн оныхоос 7 хувиар нэмэгдэж 70 хувьд хүрэв. Суурь түвшинг харьцуулсан графикийг хавсаргав.</p> <table border="1"> <caption>Үр тарианы аж ахуйн техникийн шинэчлэл, %</caption> <thead> <tr> <th>Үр</th> <th>2007</th> <th>2012</th> <th>2013</th> <th>2014</th> <th>2015</th> <th>2016</th> <th>2017</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>Шинэчлэл (%)</td> <td>30</td> <td>52</td> <td>54</td> <td>56</td> <td>61</td> <td>65</td> <td>70</td> </tr> </tbody> </table> <p>Улсын төсвийн 1.7 тэрбум төгрөгийн хөрөнгөөр дунд оврын 19 трактор, хүнсний ногооны 27 иж бүрдэл техник худалдан авах ажил зохион байгуулав. Худалдан авсан трактор, техник, тоног төхөөрөмжийг техникээр төлбөртэй үйлчилгээ үзүүлдэг ногоочид, ногоочдын хоршоо, бүлэгт 2018 онд хөнгөлөлттэй нөхцөлөөр олгох болно. Ингэснээр нийт 600 га талбайн хүнсний ногооны хөрс боловсруулах, арчлах, хураах ажлыг механикжуулах нөхцөл бүрдэв.</p>	Үр	2007	2012	2013	2014	2015	2016	2017	Шинэчлэл (%)	30	52	54	56	61	65	70	
Үр	2007	2012	2013	2014	2015	2016	2017																
Шинэчлэл (%)	30	52	54	56	61	65	70																
3.5	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 3, ЗГҮАХ-ийн 2.41 дэх заалт	Таримал ургамлын үрийн аж ахуйг хөгжүүлж, нутагшсан сортын үрийн нөөц бүрдүүлэх замаар үрийн сорт, чанарыг сайжруулах	Үрийн нөөц бүрдүүлэх аж ахуйн тоо	3	1.6 Улсын төсөв	1.5	<p>Ургамал газар тариалангийн хүрээлэнг түшиглэн Дархан-Уул аймгийн Хонгор, Өвөрхангай аймгийн Хархорин суманд анхдагч үрийн аж ахуй байгуулан техникийн шинэчлэл хийх зорилгоор улсын төсвийн 1.4 тэрбум төгрөгийн хөрөнгөөр трактор, үр тариа хураах комбайн, үрлүүр, сийрүүлүүр, хор шүршигч тус бүр 2 ширхгийг худалдан авах ажлыг зохион байгуулав. Энэхүү арга хэмжээг хэрэгжүүлснээр 2018 оноос эхлэн улаанбуудайн 2500 тн, тэжээлийн болон сэлгээний таримлын 800 тн элит үр үйлдвэрлэж дотоодын хэрэгцээгээ хангадаг болно. Тариалангийн төвийн бүсээс үр тариа, тэжээлийн таримлын үр үржүүлэх 11 аж ахуйн нэгжийг сонгон шалгарууж Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны А-157 дугаар тушаалаар үр үржүүлэх тусгай зөвшөөрөл олгож Тариалан эрхлэлтийг дэмжих сан болон Ургамал газар тариалангийн хүрээлэнтэй хамтран ажиллах гэрээ байгуулсан. ТЭДС нь 2018 оны тариалалтад зориулж 39 аж ахуйн нэгжээс үрэнд тэнцсэн 23.4 мянган тн үрийн улаанбуудай авч нөөцөлснөөс</p>	100															

							үр үржүүлэгч “Эг тариа” ХХК, “Баян дулаан уул” ХХК-аас ганд тэсвэртэй “Бурятская остистая” сортын нийт 2450 тн улаанбуудайн үр худалдан авч үрийн нөөц бүрдүүлсэн.	
3.6	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.44 дэх заалт	Өвөл, зуны хүлэмжийн аж ахуйг хөгжүүлж, хот суурин газрын хүн амыг шинэ ургацын хүнсний ногоогоор хангах	Шинээр нэмэгдэх хүлэмжийн талбайн хэмжээ, мян.м ²	100	15 Хувийн хөрөнгө оруулалт	1.8	Эдийн засгийг сэргээх хөтөлбөрийн төлөвлөгөөнд 5 га (50.0 мян.м ²) талбай бүхий өвлийн хүлэмжийн цогцолбор аж ахуй байгуулахаар тусгуулж, хүлэмжийн аж ахуй байгуулах төсөл боловсруулж Хөгжлийн банк, Үндэсний хөгжлийн газарт хүргүүлэв. Олон улсын банк, санхүүгийн байгууллагын санхүүжилтээр өвлийн болон зуны нийлэг хальсан хүлэмжийн хангамжийг нэмэгдүүлэх санал боловсруулж Өмнөд Солонгос, Турк, БНХАУ-ын зээлд хамруулах хүсэлтийг хүргүүлсэн. Улсын төсвийн 1.65 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар 720 иж бүрдэл 68.8 мянган га талбай бүхий нийлэг хальсан хүлэмжийг тендер шалгаруулан нийлүүлж, нийслэл, 21 аймгийн хүнсний ногоо тариалагчдад 30 хувийн урьдчилгаатай, 4 жилийн зээлээр олгов.	70
			Хүлэмжийн ургацын нэмэгдэх хэмжээ, мян.тонн	4			Төр хувийн хэвшлийн хөрөнгө оруулалтаар 20.0 мянган м ² өвлийн хүлэмж, 68.8 мянган м ² нийлэн хальсан хүлэмжийг байгуулсны үр дүнд орон нутагт хүнсний ногооны таримлын нэр төрөл нэмэгдэн, үйлдвэрлэл 2000.0 тонноор нэмэгдэх боломж бүрдсэн.	40/0
3.7	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.36 дахь заалт, ЗГҮАХ-ийн 2.37 дахь заалт	Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежментийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх	Үйл ажиллагааны хэрэгжилт, хувиар	100	-		Бэлчээрийн ашиглалт, хамгаалалт, нөхөн сэргээлтийн менежментийг сайжруулах эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор “Бэлчээр хамгаалах тухай” хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах Ажлын хэсгийг Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын 2017 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн А-132 дугаар тушаалаар байгуулж, Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу төслийг боловсруулах ажлыг эхлүүлэв. Монголын бэлчээр ашиглагчдын нэгдсэн холбоотой хамтран 2017 оны 09 сарын 27-28-ны өдрүүдэд зохион байгуулсан “Монгол орны бэлчээрийн үндэсний форум”-аар бэлчээрийн доройтлыг хязгаарлах, зүй зохистой ашиглалтыг нэвтрүүлэх, зохицуулалт, хариуцлагыг өндөржүүлэх бодлогын шинэчлэлийн чиглэлээр томоохон хэлэлцүүлэг хийв.	40
3.8	МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.18	“Эрүүл хүнс-Эрүүл монгол хүн” үндэсний хөтөлбөрийг боловсруулж,	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	30	-	0,2	ЗГ-ын 2016 оны 249 тогтоол, “Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах нийтлэг журам-“ын дагуу “Эрүүл хүнс-Эрүүл Монгол хүн” үндэсний хөтөлбөрийн төсөл боловсруулах нөхцөл байдлын дүн шинжилгээ, суурь судалгааг хийж, хөтөлбөрийн төсөл, дагалдах хавсралтыг боловсруулав.	

	дахь заалт	хэрэгжүүлэх, хүн амын хүнсний хангамжийг тогтворжуулах, стратегийн хүнсний бүтээгдэхүүний нийлүүлэлтийн улирлын хамаарлыг бууруулах зорилгоор “Мах, сүүний анхдугаар аян” ² -ыг зохион байгуулж, хүн амыг эрүүл, аюулгүй бүтээгдэхүүнээр хангах					Мах, сүүний анхдугаар аяныг зохион байгуулах арга хэмжээний төлөвлөгөөг ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А-45 дугаар тушаалаар батлуулж, тус төлөвлөгөөний дагуу 2017-2020 онд 5 зорилтын хүрээнд холбогдох арга хэмжээг хэрэгжүүлж байна. (Төлөвлөгөөний хэрэгжилтийг хавсаргав)	
Зорилт 4. Хүнс, хөнгөн, жижиг, дунд үйлдвэрлэлийн салбарын хөгжлийг эрчимжүүлж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлнэ								
4.1	МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 2, ЗГҮАХ-ийн 2.20 дахь заалт	Хүнсний үйлдвэрлэлийн салбарын эрх зүйн орчныг сайжруулж, хүнсний хангамж, аюулгүй байдлыг дээшлүүлэх	Шинээр болон шинэчлэн боловсруулах эрх зүйн баримт бичгийн тоо	3	0.34 Улсын төсөв	-	1.Органик хүнсний тухай хуулийн хүрээнд гарах дараах журам, аргачлалын төслийг боловсруулж Улаанбаатар хотод 20 удаа, хөдөө орон нутагт 13 удаагийн танхимын болон цахим хэлэлцүүлэг зохион байгуулж, санал авч тусгав. - Хөдөө аж ахуйн органик үйлдвэрлэл эрхлэх болон органик хүнс үйлдвэрлэхэд баримтлах багц 4 журам; - Органик болохыг илэрхийлсэн тэмдэг, тэмдэглэгээний загвар, хэрэглэх журам; - Органик хүнсийг харилцан итгэлцэлд тулгуурлан хамтран баталгаажуулахад тавих шаардлага, бүртгүүлэх болон баталгаажуулалт хийх журам; - Органик хүнсний орцын найрлага тооцох аргачлал. Дээр дурдсан журам, аргачлалын төслийг ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн 2017 оны 12 дугаар сарын 12-ны өдрийн хурлаар хэлэлцэн дэмжиж баталсан. 2.УИХ-ын нэр бүхий гишүүдээс Баяжуулсан хүнсний тухай хуулийн төслийг УИХ-д өргөн барьж, 2017 оны 04 дүгээр сарын 27-ны өдрийн УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаас хэлэлцэхээр шийдвэрлэсэн. УИХ-ын Байнгын хорооны 2017 оны 04 дүгээр тогтоолоор Баяжуулсан хүнсний тухай хуулийн төслийг	70

						<p>УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдааны холбогдох шатны хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэгт мэргэжил арга зүйн туслалцаа үзүүлэх дэд ажлын хэсэг байгуулсан бөгөөд тус яамны төлөөлөл 6 хүн орж ажиллаж байна.</p> <p>3.Зохицуулах үйлчилгээтэй хүнсний тухай хуулийн төсөл боловсруулах үндэслэлийг тогтоох нөхцөл байдал, шаардлагын тандан судалгааг хийж, бусад улсын хууль эрх зүйн орчны талаар баримтын судалгаа хийв. Хуулийн төслийг боловсруулж байна.</p> <p>4."Мах, махан бүтээгдэхүүний үйлдвэрлэл, худалдаанд мөрдөх техникийн зохицуулалт"-ын төслийг боловсруулсан. Техникийн зохицуулалтын цуврал хэлэлцүүлгийг 2017 оны 5, 9, 10 дугаар сард зохион байгуулж, хэлэлцүүлгээс гарсан саналуудыг тусгасан. УИХ-аас Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийг 2017 оны 12 дугаар сарын 08-нд баталсантай холбогдуулан, тус хуульд нийцүүлэн техникийн зохицуулалтын төслийг шинэчилж байна.</p> <p>5. Хоол үйлдвэрлэлийн салбарын эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор Хүнсний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийн холбогдох заалтад санал авах хэлэлцүүлгийг хоол үйлдвэрлэл, үйлчилгээний салбарын төрийн болон төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоод, хувийн хэвшлийн төлөөллийг оролцуулан 2017 оны 12 дугаар сарын 13-нд зохион байгуулж гарсан саналыг төсөлд нэгтгэж тусгасан.</p>	
			Хүнсний хангамж, аюулгүй байдал, хяналтын судалгаа хийх ажлын явц, хувиар	100	-	<p>1.Согтууруулах ундаа үйлдвэрлэлийн өнөөгийн байдал, бүтээгдэхүүн экспортлох нөхцөл, боломж, арга замын талаар судалгааны ажил 2017 онд гүйцэтгүүлж, хүлээж авсан.</p> <p>2.“Хүнсний аюулгүй байдал” эрдэм шинжилгээний бага хурлыг Дэлхийн хүнсний өдөр /10 дугаар сарын 16/-ийг тохиолдуулан уламжлал болгон жил бүр зохион байгуулах удирдамжийг ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А/51 дүгээр тушаалаар баталсан. Бага хурлыг 2017 оны 10 дугаар сарын 16-ны өдөр НҮБ-ын ХХААБ-ын суурин төлөөлөгчийн газар, Монголын хүнсчдийн холбоотой хамтран зохион байгуулсан. Тус бага хуралд хүнсний хангамж, хүртээмж, аюулгүй байдлын чиглэлээр нийт 33 судалгааны ажил ирснээс, зохион байгуулах ажлын хэсгийн зүгээс хянаж үзэн 20 илтгэлийг хэлэлцүүлж, оюутан болон судлаачийн тус бүр 3 илтгэл шалгаруулсан. Бага хурлыг жил бүр зохион байгуулах нь судалгааны ажлын цахим сан бүрдэх, судалгаанд тулгуурласан хүнсний аюулгүй байдлын бодлого, хөтөлбөр боловсруулахад чухал ач холбогдолтой.</p>	100


							<p>3.Засгийн газрын 2017 оны 46 дугаар тогтоолоор өгсөн үүргийн дагуу ХХААХҮЯ-наас ажлын хэсгүүдийг томилж, МХЕГ-тай хамтран улсын хэмжээнд 2017 оны 4-р сарын 17-ноос 5-р сарын 12-ны өдрийн хооронд согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрөлтэй аж ахуйн нэгжүүдийн үйл ажиллагаанд хяналт, шалгалтыг хийж гүйцэтгэсэн. Шалгалтад Ховд, Дорнод, Өмнөговь, Увс, Баян-Өлгий, Дундговь, Хөвсгөл, Архангай, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Булган, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Төв аймаг болон Улаанбаатар хотын согтууруулах ундааны үйлдвэрүүдийг хамруулсан.</p> <p>ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргын 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн А-470 дугаар тушаалаар нэр бүхий 11 компанийн согтууруулах ундаа үйлдвэрлэх тусгай зөвшөөрлийг 2017 оны 11 дүгээр сарын 09-ний өдрөөс 3 сарын хугацаагаар түдгэлзүүлж, МХЕГ, ТЕГ холбогдох аймаг, нийслэлийн ЗДТГ, татварын хэлтэст тус тус мэдэгдэл хүргүүлсэн.</p>																																																
4.2	МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.54 дэх заалт	Хөнгөн үйлдвэрийн салбарыг бодлогоор дэмжиж, өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх, хөнгөн үйлдвэрийн технологийн парк байгуулах	Ноос, арьс ширэнд олгох урамшууллын хэмжээ, тэрбум төгрөг	38	38.0 Улсын төсөв	35.3	<p>ЗГ-ын 2013 оны 394 дүгээр тогтоол, “Үндэсний боловсруулах үйлдвэрт арьс, шир бэлтгэн тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох журам”, ЗГ-ын 2015 оны 122 дугаар тогтоолоор “Хонь, тэмээний ноос бэлтгэж, үндэсний үйлдвэрт тушаасан хоршооны гишүүн малчин, мал бүхий этгээдэд мөнгөн урамшуулал олгох” журмуудын хэрэгжилтийг хангаж ажиллав. Малчдад Мал хамгаалах сангаар дамжуулан олгосон урамшууллын мэдээ:</p> <table border="1"> <thead> <tr> <th colspan="2">Он</th> <th>2016</th> <th>2017</th> </tr> </thead> <tbody> <tr> <td rowspan="5">Арьс шир</td> <td>малчны тоо</td> <td>мян.хүн</td> <td>45.1</td> <td>64.3</td> </tr> <tr> <td>урамшуулал</td> <td>сая төг</td> <td>9,500.80</td> <td>12,713.00</td> </tr> <tr> <td>Бод</td> <td>мян.ш</td> <td>168.5</td> <td>278.2</td> </tr> <tr> <td>Бог</td> <td>мян.ш</td> <td>2,324.40</td> <td>2,846.70</td> </tr> <tr> <td>арьс ширний нийт</td> <td></td> <td>2,492.90</td> <td>3,124.90</td> </tr> <tr> <td rowspan="3">Хонь, тэмээний ноос</td> <td>малчны тоо</td> <td>мян.хүн</td> <td>79.5</td> <td>92.9</td> </tr> <tr> <td>урамшуулал</td> <td>сая төг</td> <td>19,350.90</td> <td>22,637.20</td> </tr> <tr> <td>ноос</td> <td>мян.тн</td> <td>17.54</td> <td>20.6</td> </tr> <tr> <td rowspan="2">Нийт</td> <td>малчны тоо</td> <td>мян.хүн</td> <td>124.6</td> <td>157.2</td> </tr> <tr> <td>урамшуулал</td> <td>сая төг</td> <td>28,851.70</td> <td>35,350.22</td> </tr> </tbody> </table>	Он		2016	2017	Арьс шир	малчны тоо	мян.хүн	45.1	64.3	урамшуулал	сая төг	9,500.80	12,713.00	Бод	мян.ш	168.5	278.2	Бог	мян.ш	2,324.40	2,846.70	арьс ширний нийт		2,492.90	3,124.90	Хонь, тэмээний ноос	малчны тоо	мян.хүн	79.5	92.9	урамшуулал	сая төг	19,350.90	22,637.20	ноос	мян.тн	17.54	20.6	Нийт	малчны тоо	мян.хүн	124.6	157.2	урамшуулал	сая төг	28,851.70	35,350.22	100
Он		2016	2017																																																				
Арьс шир	малчны тоо	мян.хүн	45.1	64.3																																																			
	урамшуулал	сая төг	9,500.80	12,713.00																																																			
	Бод	мян.ш	168.5	278.2																																																			
	Бог	мян.ш	2,324.40	2,846.70																																																			
	арьс ширний нийт		2,492.90	3,124.90																																																			
Хонь, тэмээний ноос	малчны тоо	мян.хүн	79.5	92.9																																																			
	урамшуулал	сая төг	19,350.90	22,637.20																																																			
	ноос	мян.тн	17.54	20.6																																																			
Нийт	малчны тоо	мян.хүн	124.6	157.2																																																			
	урамшуулал	сая төг	28,851.70	35,350.22																																																			

					<div data-bbox="1150 212 1913 493" data-label="Figure"> <table border="1"> <caption>Ноосны урамшуулалын үр дүн</caption> <thead> <tr> <th>Category</th> <th>2016</th> <th>2017</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>17.54</td> <td>20.3</td> </tr> <tr> <td>2</td> <td>79.5</td> <td>92.9</td> </tr> <tr> <td>3</td> <td>17.54</td> <td>20.6</td> </tr> </tbody> </table> </div> <div data-bbox="1150 500 1913 781" data-label="Figure"> <table border="1"> <caption>Арьс ширний урамшуулалын үр дүн</caption> <thead> <tr> <th>Category</th> <th>2016</th> <th>2017</th> </tr> </thead> <tbody> <tr> <td>1</td> <td>9500.8</td> <td>12713</td> </tr> <tr> <td>2</td> <td>45.1</td> <td>64.3</td> </tr> <tr> <td>3</td> <td>2,429.90</td> <td>3,124.90</td> </tr> </tbody> </table> </div> <p>Үндэсний үйлдвэрт тушаасан ноос, арьс шир тушаасан нийт малчны тоо 26.2 хувь, мөнгөн урамшууллын хэмжээ 18.1 хувиар тус тус өссөн. 2017 онд үндэсний үйлдвэрт тушаасан түүхий эд арьс шир бэлтгэл өмнөх оноос 25 хувиар өсч, гүн боловсруулсан арьс ширний тоо хэмжээ 2012 оныхтой харьцуулбал 3.9 дахин нэмэгдсэн, ноос тушаалтын хэмжээ өмнөх оноос 17.4 хувиар өсч, ноос боловсруулах 98 үйлдвэр түүхий эдээр хангагдсан.</p>	Category	2016	2017	1	17.54	20.3	2	79.5	92.9	3	17.54	20.6	Category	2016	2017	1	9500.8	12713	2	45.1	64.3	3	2,429.90	3,124.90
Category	2016	2017																											
1	17.54	20.3																											
2	79.5	92.9																											
3	17.54	20.6																											
Category	2016	2017																											
1	9500.8	12713																											
2	45.1	64.3																											
3	2,429.90	3,124.90																											
		Технологийн парк байгуулах бэлтгэл ажлын явц, хувиар	100	-	<p>УИХ-ын 2012 оны 74 дүгээр тогтоолоор Арьс, ширний үйлдвэрүүдийг Эмээлтийн үйлдвэрийн шинэ бүс рүү шилжүүлэх арга хэмжээг 2017-12-31-ний дотор үе шаттайгаар зохион байгуулахыг Засгийн газарт даалгасан. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхээр ХХААХҮ-ийн Сайд, Нийслэлийн Засаг даргатай хамтран ажиллаж байна.</p> <p>Дээрх үйлдвэрийн бүсийг үйлдвэрлэл технологийн паркийн хэлбэрээр зохион байгуулахаар бэлтгэл ажлыг гүйцэтгэсэн. Үүнд: “Аж үйлдвэрлэлийн парк”-ийн техник эдийн засгийн үндэслэл, хэсэгчилсэн ерөнхий төлөвлөгөөний тодотгол, үерийн байгууламж, цахилгаан хангамж, технологийн болон усан хангамжийн ажлын зураг төсөл, паркийн техник технологийн түвшний үнэлгээ, паркийн цэвэрлэх байгууламжийн судалгаа</p>	40																							

						<p>зэрэг баримт бичгүүдийг боловсруулж, эрх бүхий байгууллагуудаар баталгаажуулсан. Бүтээн байгуулалтын хувьд барилга угсралтын үеийн цахилгаан хангамжийн эх үүсвэрийг байгуулаад байна.</p> <p>Засгийн газрын 2017 оны 6 дугаар сарын 20-ны өдрийн хуралдаанаар “Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн ҮТП” ОНӨТҮГ, “Налайхын барилгын материалын ҮТП” ОНӨТҮГ, “Эрдэнэ хүнс САМО” ХХК зэрэг байгууллагуудад Үйлдвэрлэл технологийн паркын үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох тухай асуудлыг хэлэлцүүлж, 178 дугаар тогтоолоор 4 жилийн хугацаатайгаар тусгай зөвшөөрлийг олгосон. Үйлдвэрлэл технологийн паркийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7.1.4. дэх заалтын дагуу дээрх паркийн удирдлагуудтай байгуулах гэрээний төслийг боловсруулж, гэрээ байгуулах бэлтгэл ажлыг хангаж байна.</p> <p>“Эмээлтийн хөнгөн үйлдвэрийн үйлдвэрлэл, технологийн парк”-ийн дэд бүтцийн бүтээн байгуулалтын ажлыг эрчимжүүлэх үүрэг бүхий ажлын хэсгийг Ерөнхий сайдын 2017 оны 173 дугаар захирамжаар байгуулж ажлаа эхлээд байна.</p>		
4.3	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 2.15 дахь заалт	Жижиг, дунд үйлдвэрлэл эрхлэгчдийг санхүү, зээлийн бодлогоор дэмжих	Санхүүжүүлэх төслийн тоо	400	20 Улсын төсөв	49.8	<p>Жижиг, дунд үйлдвэрийн зориулалттай хөнгөлөлттэй зээлийг шалгаруулах, олгох, хяналт тавих журмын төслийг боловсруулан ХХААХҮ-ийн сайдын 2017 оны А/76 тоот тушаалаар батлан хэрэгжүүлэв. Журмын хүрээнд ЖДҮХСангаас 2017 оны 4 дүгээр улирлын байдлаар жижиг, дунд үйлдвэрийг дэмжих хөнгөлөлттэй зээлийн эх үүсвэрээр 154 төслийг 49,7 тэрбум төгрөгөөр санхүүжүүлж шинэ 30 үйлдвэр байгуулагдаж, 124 үйлдвэр үйл ажиллагаагаа өргөтгөсний үр дүнд шинээр 2811 ажлын байр бий болж 1373 ажлын байр хадгалагдаж үлдсэн байна.</p> <p>/Олгосон зээл, зээлийн үр дүнг хүснэгт, графикаар харуулав/</p>	100

	Төслийн тоо	Зээлийн хэмжээ (сая.₮)	Өргөтгөсөн	Шинээр	Шинэ	Хад
Хүнсний үйлдвэр	28	8676	22	6	401	300
Хөнгөн үйлдвэр	41	11189	31	10	899	429
Газар тариалан	22	9032.5	20	2	382	150
Мал аж ахуй	26	7406.3	19	7	509	154
Барилгын үйлдвэрлэл	16	4548.11	13	3	292	109
Зоорь	9	4162	8	1	150	86
Био	3	2340	3	0	43	85
Худалдаа үйлчилгээ	8	2385	8	0	127	54
Бусад	0	0	0	0	0	0
Боловсруулах үйлдвэр	0	0	0	0	0	0
Дахивар	1	60	0	1	8	6
	154	49798.91	124	30	2811	1373

2017 онд Сум хөгжүүлэх сангаас орон нутгийн жижиг, дунд үйлдвэрийг дэмжих зорилгоор 680 төсөлд 4,5 тэрбум төгрөг, “Жижиг, дунд үйлдвэрийг хөгжүүлэх, байгаль орчныг хамгаалах хоёр үе шаттай зээлийн төсөл”-өөс 63 төслийг 29,7 тэрбум төгрөг, Зээлийн батлан даалтын сангаас 39 төслийг 7,3 тэрбум төгрөгөөр санхүүжүүлсэн.



4.4	МУТХҮБ-ын 2.1.3, Зорилт 1, ЗГҮАХ-ийн 2.48 дахь заалт	“Үндэсний үйлдвэрлэлийг хөгжүүлэх 21:100” хөтөлбөр боловсруулан батлуулж, хэрэгжилтийг эхлүүлэх	Хөтөлбөрийн хэрэгжилт, хувиар	10	0.5 Улсын Төсөв 1.3 Бусад эх үүсвэр	0.012	ХХААХҮЯ-ны ТНБД-ын 2017 оны А/57 дугаар тушаалаар “Үйлдвэржилт 21:100” хөтөлбөр боловсруулах ажлын хэсэг Хөгжлийн бодлогын баримт бичиг боловсруулах журмын дагуу хөтөлбөрийн төсөл боловсруулж, яамдаас саналыг авч, саналыг тусган ХХААХҮ-ийн сайдын зөвлөлийн 2017 оны 12 сарын хурлаар хэлэлцүүлэн Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх бэлтгэж байна. Хөтөлбөрийн төсөл боловсруулах ажлын хэсгийн зардал 8.1 сая, хэлэлцүүлгийн зардал 10.6 сая, нийт 18.7 сая төгрөг баталснаас 10.0 сая төгрөгийг зарцуулаад байна.	40
4.5	МУТХҮБ-ын 2.1.1, Зорилт 4, ЗГҮАХ-ийн 5.6.8 дахь дэдзаалт	Дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, борлуулалтыг нэмэгдүүлэх зорилгоор гадаад орнуудад “Монголд үйлдвэрлэв” үзэсгэлэн худалдааг зохион байгуулах Хөнгөн ҮБХЗГ, Хүнсний ҮБХЗГ, ЖДҮХБХЗГ	Зохион байгуулах үзэсгэлэн худалдааны тоо	2-оос доошгүй	0.2 Улсын төсөв	0.188	1. Монгол Улс, БНХАУ-ын хооронд байгуулсан “Иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглалыг хэрэгжүүлэх зорилгоор “Монгол-Хятадын Экспо” хоёр дахь удаагийн хурал, форумын арга хэмжээ, Хөрөнгө оруулалтын чуулга уулзалт, Үзэсгэлэн худалдаа, Олон улсын соёлын арга хэмжээ гэсэн 4 үндсэн чиглэлээр нийт 22 арга хэмжээг 2017 оны 9-р сарын 26-30-ны өдрүүдэд БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хөх хотноо зохион байгууллаа. Үзэсгэлэн худалдааны арга хэмжээнд Монгол Улсад үйлдвэрлэсэн хүнс, хөнгөн үйлдвэрийн онцлох бараа бүтээгдэхүүнийг зохион байгуулагч тал импортын гаалийн албан татвараас чөлөөлөн аж ахуйн нэгжид дэмжлэг үзүүлсэн. Монголын талаас 420 үндэсний үйлдвэрлэгчид оролцсон бөгөөд 3 өдрийн хугацаанд нийт 6,1 сая юань буюу 2,3 тэрбум төгрөгийн борлуулалт хийжээ. 2015 онд болсон анхдугаар үзэсгэлэн худалдаатай харьцуулахад борлуулалтын хэмжээ 5 дахин өссөн дүнтэй байна. Тус арга хэмжээний үеэр Тэсо корпораци, БНХАУ-ын Юхэйнан компанид 3 тн чацарганы үрийн тос ханган нийлэх гэрээг байгуулсан. Шинжлэх ухааны үзэсгэлэн, Олон улсын морины үзэсгэлэн зохион байгуулагдсан. Уг хоёр үзэсгэлэнгийн үеэр Монголын морины хэрэглэл болон эко бүтээгдэхүүн худалдаанд 67,000 юань буюу 21 сая төгрөгийн борлуулалт хийжээ. Тус экспо нь дотоодын үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг сурталчлах, үндэсний үйлдвэрлэгчдийн борлуулалтыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэсэн юм. 2. АНУ-ын Чикаго болон Канадын Торонто хотод “Монголд үйлдвэрлэв-2017” үзэсгэлэн худалдааг 2017 оны 9 дүгээр сарын 13-25-ны өдрүүдэд зохион байгуулж, 20 гаруй аж ахуйн нэгж ноос, ноолуур, арьс шир, оёмол хувцас, гутал, гоо сайхны бүтээгдэхүүнээр оролцож, Монгол Брэндийг сурталчилж, бизнес форум зохион байгуулж, 280,0 сая орчим төгрөгийн бараа	100

							<p>борлуулсан дүнтэй байна.</p> <p>3. БНХАУ-ын ӨМӨЗО-ны Хянган аймгийн Улаан хотод Хятад, Монголын Олон улсын органик ногоон бүтээгдэхүүний үзэсгэлэнг Мишээл экспо ХХК-тай хамтран 2017 оны 5-р сарын 25-30-ны өдрүүдэд өдрүүдэд зохион байгуулж Монголын талаас хүнс, хөнгөн үйлдвэрийн салбарын 84 ААН оролцлоо.</p>	
	Дундаж үнэлгээ							73.3